

Байгууллагын нэр-НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ

НИЙСЛЭЛИЙН ERP СИСТЕМД БҮРТГЭГДСЭН АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ИРГЭДЭЭС ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2023 ОНЫ ТАЙЛАН

2023-01-01 - 2023-11-24

2023 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр 12 цаг:00 мин

1. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй тайлан.

Ангилал	Нийт	Шийдвэрлэх шатандаа байгаа								Шийдвэрлэж хариу өгсөн					
		Хугацаанд аа байгаа		Хугацаа хэтэрсэн		Бүгд		Хугацаандаа шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Бүгд			
		1=4+7		2		3		4=2+3		5		6		7=5+6	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1800-1200 дугаарын оператор	Тоо	73	100.00%	-	-	-	-	-	-	73	100.00%	-	-	73	100.00%
	Хувь	10.46%	10.46%	-	-	-	-	-	-	10.46%	10.46%	-	-	10.46%	10.46%
Засгийн газрын 11-11 төвөөс	Тоо	478	100%	-	-	-	-	-	-	478	100%	-	-	478	100.00%
	Хувь	68.48%	68.48%	-	-	-	-	-	-	68.48%	68.48%	-	-	68.48%	68.48%
E-service	Тоо	1	100.00%	-	-	-	-	-	-	1	100.00%	-	-	1	100.00%
	Хувь	0.14%	0.14%	-	-	-	-	-	-	0.14%	0.14%	-	-	0.14%	0.14%
НМХГ тусгай дугаар	Тоо	31	100.00%	-	-	-	-	-	-	31	100.00%	-	-	31	100.00%
	Хувь	4.44%	4.44%	-	-	-	-	-	-	4.44%	4.44%	-	-	4.44%	4.44%

Нийт	Тоо	698	100.00%	-	-	-	-	-	-	698	100.00%	-	-	698	100.00%
	Хувь	100%	100%	-	-	-	-	-	-	100%	100.00%	-	-	100%	100.00%

2. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааны тайлан.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаа.	Хоног	Цаг	Минут	Нийт өргөдөл
дундаж	2	22	56	698

3. Өргөдөл, гомдлын хандалтын тайлан.

д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл, гомдлын хувь
1	Яаралтай тусламж, үйлчилгээний тухай	433	62.30%
2	Ажлаас чөлөөлөгдөх тухай	86	12.37%
3	Ажилд орох, дэвшин ажиллах тухай	25	3.60%
4	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	20	2.88%
5	Цалинтай, цалингүй чөлөө хүсэх тухай	8	1.15%
6	Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай	7	8.33%
7	Хоёр дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний тухай	6	0.86%
8	Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны тухай	69	9.93%
9	Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай	1	0.14%
10	Сургалтад хамрагдах тухай	1	0.14%
11	Агаарын бохирдол, газрын үнэлгээ, нөхөн олговрын тухай	2	0.28%
	Нийт өргөдөл, гомдлын дүн	695	100.00%

4. Хариу өгсөн хэлбэрийн тайлан.

№	Хариу өгсөн хэлбэр	Тоо
1	Программ хангамж+ Мессежээр хариу өгсөн	690
2	Программ хангамж+ Мессежээр+утсаар хариу өгсөн	5
3.	Програм хангамж + Мессеж + Албан бичгээр хариу өгсөн	1
4.	Иргэнтэй биеэр уулзаж хариу хүргүүлсэн	2

5. Шийдвэрлэсэн байдал

Шийдвэрлэсэн байдал-698	
Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл	685
Боломжгүй тухай хариу өгсөн өргөдөл	11

6. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн нэгдсэн тайлан.

Ангилал	Нийт		Шийдвэрлэх шатандаа байгаа		Шийдвэрлэж хариу өгсөн		
	Тоо	Хувь	Хугацаа хэтэрсэн	Хугацаандаа байгаа	Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрсэн	Бүгд
<i>Байгууллагын нэр-</i>							

Нийслэлийн Түргэн тусламжийн төв	698	100.00%	0	0.00%	0	0.00%	697	99.86%	1	0.14%	698	100.00%
Нийт	698	100.00%	0	0.00%	0	0.00%	697	99.86%	1	0.14%	698	100.00%

7. Өргөдөл, гомдлын төрлийн тайлан

Байгууллага	Хүсэлт		Гомдол		Талархал		Санал		Нийт
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Нийслэлийн Түргэн тусламжийн төв	148	21.20%	52	7.44%	496	71.06%	2	0.28%	698
Нийт	148	21.20%	52	7.44%	496	71.06%	2	0.28%	100.0%

9. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн нэгдсэн тайлан.

698 өргөдөл, гомдол ирсэнийг 100.00% шийдвэрлэсэн.

10. Зөрчлийн тоон үзүүлэлт-16

Д/д	Ажил	Зөрчил	Тоо	Нийт
1	Байгууллагын нэр: Нийслэлийн Түргэн тусламжийн төв	Явцын тэмдэглэл хөтлөөгүй	10	16
		Буцаалтыг 3 хоногт хийгээгүй	0	
		Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	0	
		Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	6	
		Буруу шилжүүлсэн зөрчил	16	

11. Хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлын тайлан -1 буюу 0.14%

Төрөл: Байгууллага

Бүлэг: Нийслэл, нэгж

Ангилал:

698 өргөдөл гомдлын ирсэн хэлбэр нь:

- Засгийн газрын 1800-1200-аас 73 буюу 10.46%-ыг эзэлж байна.
- Засгийн газрын 11-11 төвөөс 478 буюу 68.48%-ыг эзэлж байна.
- НМХГ тусгай дугаар 31 буюу 4.44%
- E-service 1 буюу 0.14%-ыг тус тус ирсэн.

2023 онд иргэдээс албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлт, талархлыг 2022 онтой харьцуулан үзэхэд талархал 101-ээр буюу 5.99% өссөн, гомдол 10-аар буюу 2.77%-аар буурсан сайн үзүүлэлт харагдаж байна.

№	НТТТөв	Талархал	Гомдол	Санал	Хүсэлт	Дүн
1	2022 он	395 буюу 65.07%	62 буюу 10.21%	1 буюу 0.14%	149 буюу 24.54%	607 буюу 100.00%
2	2023 он	496 буюу 71.06%	52 буюу 7.44%	2 буюу 0.28%	148 буюу 21.20%	698 буюу 100.00%



Ирсэн 52 гомдлыг 4 хоног, 10 цаг, 50 минутын хугацаанд судалж, шалгаж хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.

Гомдлыг утгаар задалж үзэхэд:

- Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харьцаа хандлагын, утсан харилцааны алдаа гаргасан-19
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний алдаа-27
- Тусламж үйлчилгээний дагуу буюу үндэслэлгүй-3
- Гомдлыг судлах боломжгүй-3 /ирсэн гомдлыг судлах хаяг, утасны дугааргүй, утсаар холбогдох боломжгүй/
- Тусламж үйлчилгээний дагуу ажилласан буюу үндэслэлгүй-3 /хаягаа мэдэхгүй очоод утсаа авахгүй дахин дуудлага ирж очиж үйлчилсэн, яаралтай 20 минутад хүлээгдэлгүй очиж тусламж үзүүлсэн тул үндэслэлгүй, уламжлалтын мэргэжлээр төгссөн эмч тус төвд ажилладаггүй, үндэслэлгүй гэх мэт/

Байгууллагад ирсэн 496 талархал нь давхардсан тоогоор 597 эмч, 487 жолооч, 7 сувилагч, тогооч, нийт давхардсан тоогоор 1091 хүний болон байгууллагын нийт хамт олны нэр дээр ирсэн байна.

Талархлын утга нь нийт хамт олонд түргэн шуурхай ирж сэтгэлээсээ үйлчилж тусалсанд, амь насыг аварсанд, эмнэлэгт хүргэж өгсөн, зөв оношилсонд, зөвлөгөө өгч биеийн байдал сайжирсанд, гэртээ төрөхөд яаралтай төрүүлж, цаг алдалгүй төрөхөд хүргэж өгсөнд баярлалаа зэрэгт талархсан талархлууд байна. Зарим талархлаас танилцуулахад:

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №91, С230207024

Япон-Монголын эмнэлэг рүү яаралтай түргэн тусламжийн хэсэгт хүүхэд халуураад байсан учраас үзүүлэх гэтэл үзэхгүй гээд буцаасан. Яаралтай түргэн тусламжийн 103 төвөөс зөвлөгөө авах гээд холбогдтол миний дуудлагыг хүлээн аваад эмч маш түргэн шуурхай ирсэн. Дуудлага хүлээн авсан оператор н.Цэрэнханд, эмч н.Мөнхзул мэргэжлийн ур чадвар гаргаж, түргэн шуурхай арга хэмжээ авч өгсөнд талархал илэрхийлье. Танд болон танай хамт олонд ажлын өндөр амжилт, амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. ХУД-ийн 15-р хорооны иргэн С.Батчулуун

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №95, G230227066

СХД-ийн түргэн тусламжийн 103 төвийн дуудлагаар ирсэн эмч М.Манлайбаатар, жолооч Э.Анхбаярт талархал илэрхийлмээр байна. Манай ээжийн бие өвдөөд дуудлага өгөхөд анхны тусламжийг цаг алдалгүй үзүүлсэн. Ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг, өргөсөн тангарагтаа үнэнч, түргэн шуурхай үйлчилгээтэй, харилцаа, хандлага сайтай хүнийг гэсэн халуун, дулаан сэтгэлтэй та бүхний ажил үйлсэд нь амжилт, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэж байна. ХУД-ийн 2-р хорооны иргэн А.Ариунбаяр

Засгийн газрын E-Sevice.№ 103, W230213001

Сайн байна уу.Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.Миний ээжийн бие сүүлийн хэдэн өдөр өвдөөд аргагүйн эрхэнд 103 дуудан эмнэлэгт хүргэгдсэн болно.Тухайн өдөр 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр 103-ын Т.Хувьзаяа жолоочтой Г.Бат-Орших гэдэг эмч ирсэн бөгөөд ,үнэхээр сэтгэл гарган үйлчилсэнд маш их баярлалаа. Миний ээж БГД-ийн 18 дугаар Хороо 45 дугаар байрны 56 тоотод амьдардаг 89

настай Төмөр гэдэг өндөр настан эмэгтэй байгаа. (олон хүнд үйлчилдэг учраас тодорхой хаягийг нь бичиж байгаа юм). Миний ээжийг 5 давхраас үүрээд Харьяа Дүүргийн эмнэлэгт нь хүлээлгэж өгөөд явсанд маш их баярлалаа. Миний ээж тэр олон давхраас үүрээд эмнэлэгт авчирсанд нь өөрөө ч их баярлаад, тэр хүүхдүүдэд хэлээд өгөөч гэснийг нь давхар дамжуулж байна. Ээжийн маань бие илааршиж, өвчин нь тодорхой хэмжээгээр намдаж байгаад үр хүүхдүүд бид ч маш их баярлаж байна. БАЯРЛАЛАА гэдэг үгнээс өөр хэлэх үг олдохгүй байна. Жолооч Т.Хувьзаяа, Эмч Г.Бат-Орших нарт болон 103-ын нийт хамт олонд баярлаж талархсанаа илэрхийлж, Та бүхний цаашдын ажилд амжилт,эрүүл энх,хамгийн сайн сайхан бүхнийг хүсье.БАЯРЛАЛАА. СБД-ийн 4-р хорооны иргэн Б.Намжилсүрэн.

Засгийн газрын 11-11 төвөөс 3-р сарын 15-нд ирсэн талархал №140, G-230315011

Би ЧД-ийн 4-р хорооны иргэн. Амралтын өдөр манай нөхрийн бие гэнэт муудаж дүүргийн 103 яаралтай түргэн тусламжийн төвд дуудлага өгсөн юм. Улмаар дуудлагын дагуу их эмч Т.Бямбасүх болон жолооч Д.Мөнх-Од хоёр нь түргэн шуурхай ирж, цаг алдахгүй яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлснээр нөхрийн минь амь нас аврагдсанд маш их баярлаж талархаж буйгаа илэрхийлж байна. Тус түргэн тусламжийн машинд ЭХО-ны аппарат байсан бөгөөд энэ нь маш их хэрэг боллоо. Гэвч энэ ЭХО-ны аппарат нь дүүрэг болгонд ганц ганц л байдаг гэж байна. Ийм хэрэгтэй аппаратыг түргэний машин бүрт авч явдаг болмоор байна. Мөн Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг өрхийн эмнэлэг нь энэ мэт аппарат тоног төхөөрөмжөөр сайжирчихвал дараагийн шат буюу дүүрэг рүү яваад байхгүй шүү дээ. Таны цаашдын ажил хөдөлмөр, амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж байна. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү./Эмчлүүлэгч Батжаргалын гэр бүлээс/

Засгийн газрын 11-11 төвөөс 3-р сарын 15-нд ирсэн талархал №145, G-230315098

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн СХД-ийн салбарын эмч Б.Дашням болон жолооч Б.Ганболд нарт талархал илэрхийлье. Түргэн шуурхай үйлчилгээтэй, эелдэг найрсаг харилцаатай та бүхэнд талархаж байна. Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсэж, амьдралд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. СХД-ийн 22-р хорооны иргэн М.Нэргүй.

Засгийн газрын 11-11 төвөөс 3-р сарын 16-нд ирсэн талархал №146, G-230316019

ЧД-ийн 103 яаралтай түргэн тусламжийн 3-р ээлжийн эмч А.Золжаргал, Ц.Отгонбаяр, жолооч С.Энхбаяр, А.Ганзориг нарт талархал илэрхийлмээр байна. Манай гэр бүл угаартаж амь нас эрсдэх аюултай байдалд байсныг тус албан хаагчид маань түргэн шуурхай ирж, яаралтай тусламж үйлчилгээг цаг алдахгүй үзүүлж авран хамгаалж өгсөн явдалд талархал илэрхийлмээр байна. Та бүгдийн цаашдын ажил хөдөлмөр, амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж байна. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү. ЧД-ийн 17-р хорооны иргэн Б.Амаржаргал.

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №483, G231122013

СБД-ийн 20-р хороо Сэлхэд ЧД-ийн түргэн тусламжийн эмч Ч.Хулан жолооч Ч.Тогтбаатар нар нь түргэн шуурхай ирж эмнэлгийн тусламж үзүүлсэнд баярлалаа. Ажлын өндөр амжилт хүсье. Холбогдох газар нь уламжилж өгнө үү. Налайх 5-р хорооны иргэн С.Гансүх

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №484, G231123024

Нийслэлийн түргэн тусламжийн 1 дүгээр ээлжийн ахлах эмч А.Хулангуа эмч Х.Энхбат жолооч нь Т. Хувьзаяа нар нь хурдан шуурхай,ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг, өргөсөн тангарагтаа үнэнч, ард иргэдээ гэсэн халуун сэтгэлтэй та нартаа ажил үйлсэд нь амжилт, амьдралд нь аз жаргал сайн сайхныг хүсье. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү. БГД-ийн 13-р хорооны иргэн Ч.Баярмаа

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №485, G231123067

ХУД-ийн 103 яаралтай түргэн тусламжийн нярайн эмч Н.Тунгалаг, жолооч Г.Баасандорж нарт талархал дэвшүүлж байна. 15 хоногтой хоёр ихэр нярай маань хэд хоног гэдсэн дүүрээд хямраад шөнө яаралтай тусламж дуудсан юм. Улмаар тус эмч жолооч нар нь маш хурдан шуурхай ирээд шаардлагатай тусламж үйлчилгээг маш сайхан үзүүлж хоёр нярайн минь гэдэсний дүүрэнг арилж тайвшраад унтсан. Ажил мэргэжилдээ эзэн болсон чадварлаг эмч мэргэжилтэн та бүхэнд маш их баярлан талархаж байна, Та бүхэндээ ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөж байна. Уламжилж өгнө үү. ХУД-ийн 18-р хорооны иргэн М.Шүрээ

Ирсэн 52 гомдлыг судалж шалган, өглөөний яриан дээр эмч, ахлах эмч, салбарын эрхлэгч нарт тохиолдол, гомдлыг танилцуулж, ажил үйлчилгээн дээр анхаарч ажиллахыг анхааруулж, салбарын чанарын багийн хурал хийж, хугацаат үүрэг даалгавар өгч, дахин алдахаас сэргийлж ажилласан.

Ирсэн 52 гомдлыг судалж үзэхэд

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой алдаа-27 буюу 51.92%%
2. Харьцаа хандлагатай холбоотой, утсан харилцааны алдаа-19 буюу 48.08%

Боломжгүй тухай хариу өгсөн өргөдөл-3 нь Хууль зүйн яамны Цагдаагийн ерөнхий газрын харьяа мэдээлэл шуурхай удирдлагын төвийн насанд хүрэгчдийн дуудлага хүлээн авагч оператортай холбоотой, алслагдсан хорооны ЭМТ-ийн 103-тай холбоотой, дүүргийн эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн эмчтэй холбоотой гомдлуудыг судалж буцаасан./

Гомдлын дагуу дараах ажлыг хийж, сайжруулан ажиллаж байна. Үүнд:

- 2) Хурлын протоколоор сануулсан-47
- 3) Удирдлагын зөвлөлийн хурлаар-1
- 4) Эмч нарын ярианд анхааруулсан- 195 удаа
- 5) Ёс зүйн хороонд шилжүүлж шийдвэрлүүлсэн-8

- Гомдлын шалтгаанд дүн шинжилгээ хийж, ЧАБ-ын албаны 7 удаагийн болон салбар төвийн багийн 40 удаагийн хурлыг тохиолдол бүрд хийж, тохиолдлыг бүртгэн, эмнэл зүйн тохиолдолд суурилсан персентэйшн бэлдүүлж, хэлэлцүүлэг хийж, сургалт зохион байгуулах замаар мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлж, дахин алдахаас сэргийлж ажилласан.

- Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт 25 удаа. Нийт давхардсан тоогоор 791 хүн хамрагдсан.
- 2023 онд хийгдсэн зарим сургалтаас:
 - Эх барихын 2023 оны 04 сарын 19-ны өдөр "Жирэмсэн эмэгтэйн үзлэг, хяналт, өртөмтгий, өндөр эрсдэлтэй жирэмсэн, насанд хүрээгүй охидын жирэмслэлтийн хяналт, онцлог" сургалтыг Өргөө амаржих газрын Амбулаторийн тасгийн эрхлэгч Б.Оюунчулуун эмч удирдан хичээлийг орлоо. Сургалтад нийт 55 их хамрагдав.
 - 2023 оны 4 сарын 11-15 өдрүүдэд лавшлуурсан тусламжийн сургалтыг ээлжийн 1-3 их эмчид зохион байуулав.
 - НЭМГ-ын Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны А/06 "НТТТөвийн ёс зүйн хэсгийн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай", ЭМС А/01 албан даалгавар Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын сахилга хариуцлагыг сайжруулах тухай", ЭМС 2019.09.04-ний өдрийн "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм" батлах тухай А/406 дугаар тушаал, ЭМС-ын 2017.06.30 өдрийн "Дүрэм батлах тухай А/256 дугаар тушаал, МУЗГ-ын тогтоол 2019.01.23 өдрийн "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм" дүрэм батлах тухай 33 дугаар тогтоол, Монгол Улсын Их хурлаас 2021 оны 12 сарын 17-ны өдөр батлагдсан "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай" хуулийг 1 сарын 24-26 хооронд өглөөний байгууллагын онлайн хурал болон салбарын хурал дээр нийт эмч нарт уншиж танилцуулж, мэдээлэлийн самбарт байршуулсан.
 - Нийслэлийн эх барих, нярайн газар дээрх болон эмнэлэг хүртэлх тусламж үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй үзүүлэхэд, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, дуудлагын хуудас бичилтийг сайжруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, эрүүл мэндийн сайдын 2020 оны А/318 тоот журмын хэрэгжилтийг хангах хүрээнд эх барихын олон талт ажил, эмнэлзүйн сургалтыг зохион байгуулж байна. Ажлын байран дээрх дадлага сургалтыг зохион байгуулж Нийслэлийн төрөлжсөн амаржих газрууд руу албан бичиг хүргүүлж, ажлын байран дээрх сургалтын гэрээ байгуулж, дараах чиглэлийн хүрээнд сургалтыг зохион байгууллаа. Дүүрэг дүүргийн амаржих газруудад тус төвийн 5 салбарын нийт 123 их эмчийг хуваарилан сургалтыг зохион байгуулсан.



- 2023 оны 3-р сарын 12-оос эхлэн СХС эмч нар Нийслэлийн хүрээ амаржих газарт эх барих чиглэлээр гардан үйлдэлийн сургалтанд ирц бүрэн оролцож байгаа.
- 05 дугаар сарын 22-нд НЭМГазар дээр харьяа байгууллагын бүх чанарын менежерүүдийн нэгдсэн танхимын хуралд оролцсон.
- 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн хэмжээний зарим тоо мэдээ болон туршлага солилцох хуралд оролцсон.
- Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн нийт салбар төвийн эмч, ахлах эмч, салбарын эрхлэгч нарт Цэргийн төв эмнэлгийн Мэдрэлийн тасгийн эрхлэгч ахмад Н.Золжаргал эмч 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр "Тархины цус хомсрох харвалттай өвчтөний эмчилгээний ерөнхий зарчим" сургалтыг зохион байгуулав. Нийт 55 их эмч хамрагдсан. Сургалтыг онлайн орчинд зүүмээр зохион байгуулсан.
- 2023 оны 05 дугаар сарын 11-нд Цэргийн төв эмнэлгийн хурлын зааланд хордлогын тасгийн их эмч хошууч Д.Оролзод, М.Цэнгэлмаа нар "Зонхилон тохиолдох эм, химийн хурц хордлого, угаарын үеийн тусламж үйлчилгээ" сэдвүүдээр сургалт орсон. Нийт 43 их эмч хамрагдаж мэдлэг мэргэжлээ бататгасан.
- Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн нийт салбар төвийн эмч, ахлах эмч, салбарын эрхлэгч нарт Цэргийн төв эмнэлгийн Мэдрэлийн тасгийн эрхлэгч ахмад Н.Золжаргал эмч 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр "Тархины цус хомсрох харвалттай өвчтөний эмчилгээний ерөнхий зарчим" сургалтыг зохион байгуулав. Нийт 55 их эмч хамрагдсан. Сургалтыг онлайн орчинд зүүмээр зохион байгуулав.
- 2023 оны 05 дугаар сарын 11-нд Цэргийн төв эмнэлгийн хурлын зааланд хордлогын тасгийн их эмч хошууч Д.Оролзод, М.Цэнгэлмаа нар "Зонхилон тохиолдох эм, химийн хурц хордлого, угаарын үеийн тусламж үйлчилгээ" сэдвүүдээр сургалт орсон. Нийт 43 их эмч хамрагдаж мэдлэг мэргэжлээ бататгасан.
- НЭМГ-ын Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны А/06 "НТТТөвийн ёс зүйн хэсгийн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай", ЭМС А/01 албан даалгавар Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын сахилга хариуцлагыг сайжруулах тухай", ЭМС 2019.09.04-ний өдрийн "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм" батлах тухай А/406 дугаар тушаал, ЭМС-ын 2017.06.30 өдрийн "Дүрэм батлах тухай А/256 дугаар тушаал, МУЗГ-ын тогтоол 2019.01.23 өдрийн "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм" дүрэм батлах тухай 33 дугаар тогтоол, Монгол Улсын Их хурлаас 2021 оны 12 сарын 17-ны өдөр батлагдсан "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай"

хуулийг 1 сарын 24-26 хооронд өглөөний байгууллагын онлайн хурал болон салбарын хурал дээр нийт эмч нарт уншиж танилцуулж, мэдээлэлийн самбарт байршуулсан.

- Байгууллагын ёс зүйн хэсгийн хороо 7 хүний бүрэлдэхүүнтэй шинээр байгуулагдан, 2023 оны 01 дүгээр сарын 23-нд хуралдаж, төлөвлөгөөнд санал авсан.

- Тус төвийн дуудлагад үйлчилж буй 95 жолоочид тусгай дуут дохио ашиглах журам болон замын хөдөлгөөний дүрмийн талаарх мэдлэг олгох гурван цагийн сургалтыг СБД –ийн ЗЦГ-ын дэслэгч Гантулга зохион байгуулсан.



- 10 жолоочийг сургагч багшаар бэлтгэн амилуулах тусламжийн сургалтад хамруулан гурван ээлжийн 96 жолоочийг хоёр хувингийн арга болон сэдэвт сургалтад хамруулсан.

- Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар албан даалгаврын хүрээнд 1 сарын 31-ээс 2 сарын 01 хооронд ХУНЭ дээр "Амь тэнссэн үед хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээний чиглэл"-ээр ажлын байрны сургалтанд нийт 10 эмч хамрагдсан.



- Өртөлт, түүнээс сэргийлэх арга хэмжээ, мэдлэг шалгах сорил, ЭТҮХХ, түүнээс сэргийлэх нь сургалтыг сургалтын албатай хамтран зохион байгуулсан.

- Гэрээт байгууллагаар ариутгалын биологийн индикаторын дүгнэлт гаргуулсан.

- Эмч, сувилагч нарт гар халдваргүйжүүлэх дараалал, 5 мөчлөгийн гардан үйлдлийн хяналтыг тухайн салбар нэгж дээр зохион байгуулан ажиллаж байна.

- Ёс зүй, хэм хэмжээг сайжруулах зорилгоор тус төвийн ҮЭХ-той МҮЭХ-той хамтарсан сургалтыг 4 дугаар сарын 8-10-нд зохион байгуулсан "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй"-н сургалтад нийт 385 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн нар хамрагдан суусан.



- Ес зүйн сургалтын талаар мэдээлэл 1 удаа байршуулсан. Байгууллагын ёс зүйн хэсгийн хороо 7 хүний бүрэлдэхүүнтэй шинээр байгуулагдан, 2023 оны 01 дүгээр сарын 23-нд хуралдаж, төлөвлөгөөнд санал авсан.

- Дуудлагын жолооч нарыг эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харьцаа хандлагын сургалтыг 2023 оны 3 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулж гурван ээлжийн нийт 98 жолооч хамрагдсан. Ёс зүйн сургалтыг Ёс зүйн хороон дарга Д.Дариймаа удирдан эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбогдох дүрэм, журмуудыг танилцуулсан.
- 223 оны 11 дүгээр сард нийт эмч, жолооч нарын мэлгэжлийн ур чадвар үнэлэх, түвшин тогтоох шалгалтыг 17-оос эхлэн авч, сургалтыг дүүргийн нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасагтай хамтран зохион байгуулахаар гэрээ хэлцэл хийх шатандаа явж байна.
- ХӨЦМ-ийн эмнэл зүйн сургалтыг ажилд шинээр орсон эмч нарт 12-р сард зохион байгуулахаар ажиллаж байна.
- Өргөдөл, гомдлын 14 хоногийн явцын тайланг цахимаар НЭМГ-ын мэргэжилтэнд файлаар нийт 20 удаа хүргүүлэн ажилласан.

Дүгнэлт:

698 өргөдөл гомдлын ирсэн хэлбэр нь:

- Засгийн газрын 1800-1200-аас 73 буюу 10.46%-ыг эзэлж байна.
- Засгийн газрын 11-11 төвөөс 478 буюу 68.48%-ыг эзэлж байна.
- НМХГ тусгай дугаар 31 буюу 4.44%
- E-service 1 буюу 0.14%-ыг тус тус ирсэн.

2023 онд иргэдээс албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлт, талархлыг 2022 онтой харьцуулан үзэхэд талархал 101-ээр буюу 5.99% өссөн, гомдол 10-аар буюу 2.77%-аар буурсан сайн үзүүлэлт харагдаж байна.

Мөн байгууллагын ёс зүйн хороо шинэчлэгдэн байгуулагдан үр дүнтэй ажиллаж байна.

ХЯНАСАН: НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН ДАРГА

ТАЙЛАН ГАРГАСАН: ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫ МЕНЕЖЕР



С.АРИУНБОЛД

З.ЭНХЦЭЦЭГ